



МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Харилцаа холбоо, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудан холбооны салбарын ололт, шинэ төрлийн үйлчилгээ хэрэглээний их өгөгдөл, нээлттэй өгөгдөл, зүйлсийн интернэт, цахим үйлчилгээний хөгжүүлэлт, үүлэн тооцоолол, хиймэл оюун ухаан зэрэг нь бусад нийгэм эдийн засгийн салбарт ялангуяа төрийн үйлчилгээ, цахим боловсрол, эрүүл мэнд, банк санхүү, ухаалаг хот, үүлэн квантын технологийн дэд бүтэц зэрэг шинэ сүлжээ, мэдээллийн дэд бүтцийг бүрдүүлж байна.

Харилцаа холбооны салбарын үйлчилгээ, хэрэглээг нийгэм, эдийн засгийн бусад салбарт нэвтрүүлэхдээ цахим орчин, сүлжээ, технологийн салбар хоорондын уялдаа холбоог хангах, урт ба дунд хугацааны нэгдсэн бодлого төлөвлөлтөд нийцүүлэн зохицуулалтын орчныг шинэчлэхийг шаардаж байна.

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх) нь манай улсад үүсэж хөгжсөн анхны зохицуулах байгууллага бөгөөд 1995 онд Дэд бүтцийн хөгжлийн яамны Харилцаа холбооны зохицуулах зөвлөл, 2002 оноос бие даасан Харилцаа холбооны зохицуулах хороо байгуулагдаж өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн ХХЗХ-ны Дарга, орон тооны бус 6 гишүүнийг Монгол улсын Ерөнхий сайдын Захирамжаар томилдог ба Хорооны хуралдаанаар тогтоол батлан шийдвэрлэдэг болно.

Хорооны орон тооны бус гишүүн Алтанхуяг овогтой Үйлстөгөлдөрийн томилгооны хугацаа 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөр дуусгавар болсон. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Орон тооны бус гишүүн томилох тухай” 74 тоот захирамжаар Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн Бадамрай овогтой Анхбаатар, Банзрагч овогтой Батзориг нарыг шинээр, Алтанхуяг овогтой Үйлстөгөлдөрийг улиран Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар тус тус томилов.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Даргаар гишүүн томилох тухай” 47 тоот захирамжаар Харилцаа холбооны зохицуулах хорооны даргаар Гончиг овогтой Чинзоригийг улираан томилов.



ХХЗХ нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор шинэчлэн баталсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, ирэх 2 жилийн төсвийн төсөөлөл”-ийн төслийг тус тус Хорооны хуралдаанаар хэлэлцэж, Хорооны хуралдааны тогтоол, хавсралтаар баталдаг хуулийн зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөж байна.

ХХЗХ-ны жил бүрийн “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилт болон үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг тус тус гарган ЗГХЭГ-т хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдад хэрэгжилтийг шууд тайлагнаж ажилладаг болно. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж, байгууллагын орлого зардлын төлөвлөгөөнд хяналт тавин хэрэгжүүлдэг болно.

УИХ-аас баталсан хууль, тогтоомж болон Засгийн газрын 2016 оны 256 дугаар тогтоолоор баталсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм, 2020 оны 65 тоот тогтоолоор дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, хорооны хуралдааны дэгийн хүрээнд удирдлагаас өгсөн удирдамж чиглэл, “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023-2025 оны үйл ажиллагааны стратеги”, Хорооны 2023 оны 155 дугаар тогтоолоор баталж, Хорооны 2024 оны 12 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний зорилт, заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү стратеги, зорилго зорилт, төлөвлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн хэрэгжилтийг зөв, зохистой аргаар түргэн шуурхай хангуулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай гол нөөцийг үр ашигтай удирдах, төлөвлөлтийг оновчтой болгох, гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах зэрэг Зохицуулах хорооны дотоод хэрэгцээ, шаардлагыг хангахад чухал ач холбогдолтой алхам болсон ба жил бүр системтэйгээр төлөвлөж, оролцогч талуудын харилцаа, хүний болон бусад шаардлагатай нөөцийг стратеги суурьтай удирдаж, жил бүрийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажиллаж байна.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос 2024 оны тайлант хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны 2023 оны 155 тоот тогтоолын хавсралтаар баталж, Хорооны 2024 оны 12 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан **“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого зардлын төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөлөл”**-д заасан зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ (зохицуулалтын баримт бичиг, техникийн болон зохицуулалтын нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, ашиглалт, төлбөрийн хэмжээ, төсөл хөтөлбөр)-ний талаар Даргын зөвлөл, Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж ажилласан.



ХХЗХ-ны хуралдаанаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 3 бүлэгт стратегийн зорилтын хүрээнд 308 (үүнээс, 208 хугацаатай, 103 байнга хэрэгжүүлэх) бүтээгдэхүүн, зорилт заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж, хорооны ажлын алба, бүтцийн нэгж 11 субъектээс 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан бүтээгдэхүүн, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллав.

Тайлангийн хугацаанд буюу 2024 оны жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ны 2024 оны ээлжит, ээлжит бус 30 удаагийн хуралдааныг тус тус зохион байгуулж, нийтдээ 140 гаруй асуудлыг хэлэлцэн хуралдаж, зохицуулах хорооны хуралдаанаас баталсан 263 тогтоол шийдвэр болон 14 удаагийн хуралдааны тэмдэглэлийн нэгдсэн жагсаалтыг тайлангийн хавсралтад нэгтгэн үзүүлэв. (Хавсралт-1: 2024 оны тогтоол, шийдвэрийн жагсаалт, хэрэгжилтийн тайлан):

- ХХЗХ-ноос ХЗДХЯ-аар захиргааны хэм хэмжээний актад хянуулан бүртгүүлсэн баталсан тогтоол шийдвэрийн талаар судалгааг ирүүлсэн загварын дагуу боловсруулж, Даргын 2024 оны 06 дугаар сар, 12 дугаар сарын эцсийн байдлаар нэгтгэн албан тоотоор хүргүүлэн ажилласан;
- Зохицуулах хорооны үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг 40 гаруй байгаа бөгөөд 2024 онд ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд Хорооны хуралдаанаар баталсан 6 баримт бичгийн шинэчилсэн, нэмэлт, өөрчлөлт оруулсан болон 1 тогтоолын хасалтыг хянуулан хөдөлгөөн хийлгэсэн;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 дугаар сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нийцүүлж, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр тогтоож баталсан 3;
- Зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, харилцан холболт, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, зохицуулалтын үйлчилгээний хөлс, төлбөрийн хэмжээ, техникийн нөхцөл шаардлага, дугаарлалт, дүрэм журмыг ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 2 баримт бичиг, үнэ тарифыг тогтоож зохих хууль тогтоомжийн дагуу хүргүүлэн хянуулж шинээр бүртгүүлсэн болно.
- Шинээр болон шинэчлэн, нэгтгэн боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, баталгаажуулалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-4;
- Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-1;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу шинээр баталсан, шинэчилсэн, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хүчингүй болгосон-13 тогтоол, хавсралт баримт бичиг зэрэг болно.



Хорооны дарга, Ажлын албаны даргаас өгсөн үүрэг, чиглэл болон 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн, ДЗХ-ны үүрэг даалгаврыг тухай бүр биелэлтийг гаргаж, тайлагнан ажилласан болно. ХХЗХ-ны хуралдааны 2024 оны 01-04 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг холбогдох бүтцийн нэгжээс авч нэгтгэж эдгээр төлөвлөгөөг Хорооны даргаар 2024 оны тухай бүр тус тус батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр дүгнэн тайлагнав.

НЭГ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас харилцаа холбоо (цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийг)-ны салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжил, хүний хөгжлийг хурдасгагч, мэдлэгт суурилсан нийгэм байгуулах, эдгээрийг дэмжих хөшүүрэг гэж тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газраас харилцаа холбооны салбар, цахим засгийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг шинэчлэх, төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэргүүний техник технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх хүрээнд нэвтрүүлэх нь улс орны тогтвортой хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл гэж үзэж байгаа билээ.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Харилцаа холбооны тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Шуудангийн тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Радио долгионы тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), Өргөн нэвтрүүлгийн тухай (2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан), “Зөвшөөрлийн тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”; “Зөрчлийн тухай” болон холбогдох Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж эдгээр хуулиудад тусгайлан заасан бүрэн эрх, чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеэр радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллахад шаардагдах зардлын төсвийг гаргаж, холбогдох санхүүжилтийг төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд болон УИХ-ын Байнгын хороонд хүргүүлж, хамтран ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны ажлын алба, бүтцийн нэгж, ажлын хэсгээс 2024 онд УИХ-аас баталсан Хууль, тогтоомжийг боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтууд, салбарын болон салбар дундын зохицуулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан хуулийн төслийн ажлын



хэсэг, хэлэлцүүлэгт оролцож, Хорооны саналыг албан тоотоор хүргүүлж хамтран ажиллав. Үүнд:

- Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн (анхдагч) төсөл;
- *Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс ирүүлсэн Монгол Дохионы хэлний тухай хуулийн төсөл;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийг дагалдаж өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
- Зохицуулах хорооны даргын А/207 тоот тушаалаар баталсан ажлын хэсэг дижитал зохицуулалтын олон улсын чиг хандлага болон бусад улс орнуудын зохицуулах байгууллагуудын Сэндбокс зохицуулалтын орчин нэвтрүүлсэн туршлага, хууль эрхзүйн орчны байдал, Монгол улсад Сэндбокс зохицуулалтын орчин нэвтрүүлсэн ижил төстэй байгууллагуудын туршлага, Харилцаа холбооны салбарт Сэндбокс зохицуулалтын орчин нэвтрүүлэх хууль эрхзүйн орчин, нэвтрүүлэх боломжийн талаар судалгааг хийж, санал дүгнэлт боловсруулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд Сэндбоксын зохицуулалтыг тусгуулахаар саналаа УИХ-ын холбогдох ажлын хэсэг;
- Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөлд орон сууцны барилга дотор харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг байгуулахтай үүсэж буй асуудал, үүнтэй холбоотой СӨХ-ийн хуульд тусгах шаардлагатай талаар санал;
- Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт, зохицуулалтын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн төсөл (нийт 15 саналыг хүргүүлсэн);
- Захиргааны хэм хэмжээний актуудыг цэгцлэх, давхардлыг арилгах ажлын хүрээнд ӨНТХуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал (ЦХИХХЯ, ХЗДХЯ);
- "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах" ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төсөл;
- Засгийн газрын 2023 оны 364 дугаар тогтоолоор батлагдсан "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм", "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журам"-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11-д заасан "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төсөлд 6 санал, 25.13-т заасан "Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ын төсөлд 10 саналыг хүргүүлэв;
- "Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бага насны хүүхэд сураггүй алга болсон, олдсон тухай хойшлуулшгүй мэдээллийг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээд үнэ төлбөргүй, нийтэд мэдээлэх журам"-ын төсөл;
- ЭХЗХ-той хамтран 2024 оны 11 сард хийсэн эрчим хүчний тарифийн шинэчлэлтийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж, цахилгаан эрчим хүчний тарифын ангиллыг уул уурхай, хүнд аж үйлдвэрээс салгаж, тусад нь үүрэн телефон холбооны гэсэн ангиллыг тусгаж ажилласан зэрэг болно.



ХХЗХ-ны ажлын алба, бүтцийн нэгжээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг идэвхжүүлэх ажлын хүрээнд 2023-2024 онд хийгдсэн ажил, телевиз радиогоор нэвтрүүлсэн “Хүнсний хувьсгал” нэвтрүүлгийн мониторингийн тайлан; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан; Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний биелэлт; ЦХХХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, мэдээллийг тус тус боловсруулан албан тоотоор хүргүүлэн хамтран ажилласан.

ХХЗХ-ноос Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой бэлтгэл ажлуудыг зохион байгуулан ажиллав. Тухайлбал: Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар ажлын хэсгээс боловсруулсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн төслийн танилцуулга, судалгааны тайлан, журмын төсөл, саналын товчоо, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, нөлөөллийн шинжилгээ болон Хорооны хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус авч хэлэлцээд, энэхүү хуралдааны үеэр Хорооны дарга болон гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн төслийг дэмжиж, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэв. Энэхүү журам нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2024 оны 14 дугаар тогтоолоор батлагдаж, улсын нэгдсэн бүртгэлийн 6478 дугаарт бүртгүүлсэн болно. УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд ашиглах <https://election.crc.gov.mn> цахим систем (хуудас) ажиллуулж, веб сайт, цахим хуудасны бүртгэл хийж, энэ цахим хуудсаар дамжуулан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 47.1.1, 47.1.2-т заасны дагуу нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудасны бүртгэл хийх, сонгуулийн 13 тойргийн хороодын бүртгэгч ажилтнаар дамжуулан 820 нэр дэвшигчдийн 2658 веб болон олон нийтийн цахим хуудас бүртгэсэн. Хуулийн 47.1.3-т зааснаар 245 веб сайт системд бүртгэн хяналт тавьж ажиллав. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт журамд заасан чиг үүргийн хүрээнд цахим орчны сонгуулийн сурталчилгаанд 2024 оны 06 дугаар сарын 10-28-ны өдрүүдэд хяналт, мониторинг хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллав. Ажлын хэсгийн тайланг Хорооны 2024 оны ээлжит 20 дугаар хуралдаанд танилцуулсан ба СЕХ-нд 2024 оны 07 дугаар сарын 06-ны өдөр албан бичгээр тайланг хүргүүлэв.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.20 дах заалтыг үндэслэн боловсруулсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын төсөл, мэдэгдлийн болон тайлангийн маягт, холбогдох танилцуулгыг авч хэлэлцээд, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын төсөл, холбогдох



маягтыг зарчмын хувьд дэмжиж, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэв. Энэхүү журмын төслийг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд албан тоотоор хүргүүлж, Сонгуулийн Ерөнхий хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулах, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 18/22 тоот тогтоолыг хүчингүй болгох чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллав. УИХ-ын Сонгуулийн тухай хууль, Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журамд заасан чиг үүргийн хүрээнд цахим орчны сонгуулийн сурталчилгаанд 2024 оны 06 дугаар сарын 10-28-ны өдрүүдэд хяналт, мониторинг хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллав. Ажлын хэсгийн тайланг Хорооны 2024 оны ээлжит 20 дугаар хуралдаанд танилцуулсан ба СЕХ-нд 2024 оны 07 дугаар сард албан бичгээр тайланг хүргүүлэв.

Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал (АНСДИТХ)-ын Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9-д заасныг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төслийг боловсруулж СЕХ-нд 2024 оны 09-р сарын 3-ны өдрийн 01/1651 тоот албан бичгээр журмыг батлуулахаар холбогдох хавсралтуудын хамт хүргүүлсэн. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам” нь Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 09-р сарын 09-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан. Сонгуулийн тухай хууль болон Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын хэрэгжилтийг хангуулах, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс зохицуулах хорооны цахим хуудсанд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Сонгууль-2024” хуудас нээн, сонгуулийн сурталчилгааны цахим орчны хяналт, мониторинг тавих үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, зөвлөмж мэдээлэл, цахим орчны бүртгэл, тайлан мэдээ, мэдээллийг нийтэлж олон нийтэд хүргэж ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2024 оны А/240 тоот тушаалаар АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих ажлын бэлтгэлийг хангах, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааг уялдуулах, зохион байгуулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сүлжээ ба үйлчилгээний найдвартай ажиллагааг хангуулах, сонгуулийн сурталчилгаанд хяналт мониторинг хийх, мэдээ, тайлан боловсруулж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авах, нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажиллав. Цахим орчны хяналт мониторингийн ажлын хэсэг 2024 оны 9-р сараас эхлэн цахим орчин ашиглан явуулах сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих бэлтгэл ажлыг зохион байгуулж, сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс сонгуулийн санал авах өдрийг дуусталх хугацаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажилласан. Харилцаа холбооны зохицуулах хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт журамд заасан чиг үүргийн хүрээнд цахим орчны сонгуулийн сурталчилгаанд 2024 оны 09-р сарын 26-ны өдрөөс 10-р сарын 12-ны өдрийг дуусталх нийт 18 хоногийн



хугацаанд хяналт, мониторинг хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан тайланг СЕХ-нд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 01/2018 тоот албан бичгээр тайлан хүргүүлсэн.

МҮОНРТ болон бусад радио, телевизүүдээр нэвтрүүлсэн АНСДИТХ-ын сонгуулийн сурталчилгааны нийт хугацааны сурталчилгааны нэвтрүүлэг, мэдээ, сонгогчдын боловсролын нэвтрүүлэг, мэтгэлцээний нэвтрүүлэг болон дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн нэгдсэн тайланг тус Хорооны цахим хуудсанд нээлттэй байршуулж мэдээлсэн. <https://www.crc.gov.mn/pages/show/ansdith-yn-eelzhit-songuul-hyanalt-monitoringijn-tajlan>

СЕХ-ноос АНСДИТХ-ын сонгуулийн сурталчилгааны үеэр радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт мониторинг хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны зардалд зориулан ХХЗХ-нд олгосон зардлын санхүүжилтын гүйцэтгэлийн тайланг нягтлан бодох бүртгэлийн шаардлага хангасан байдлаар гаргаж СЕХ-нд хүргүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шуурхай мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий цахим crccscouncil@crc.gov.mn суваг /имэйл/ үүсгэн ажиллаж байна.

ХХЗХ нь Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, ЦХИХХЯ-тай хамтран 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдлын талаар үндэсний хэмжээний арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 25-нд “Кибер Тусгаар тогтнол-2024” форум зохион байгуулав. Кибер аюулгүй байдлын чиглэлээр гадаад орны ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудын туршлагыг судлах, алба хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр богино хугацааны сургалтад хамруулах ажлын хүрээнд Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний төслийг ЦХИХХЯ, ТЕГ, КХЗТТөвүүд, ЦЕГ, ЗХЖШ, ҮАБЗ зэрэг байгууллагуудтай хамтран боловсруулж, хамтран ажиллав.

ХХЗХ-ны төлөөлөл 2024 оны 12 дугаар сарын 03-нд Монгол Улсын терроризмтэй тэмцэх зөвлөлөөс зохион байгуулагдсан гишүүн байгууллагуудын хамтарсан уулзалт арга хэмжээнд оролцож, кибер аюулгүй байдлын талаар мэдээлэл, санал солилцож ажиллав.

ХОЁР.
ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ХОРООНЫ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ БОЛОН
ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны тогтоол, шийдвэрийн хэрэгжилт: ХХЗХ-ны ажлын албанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар, харилцаа холбоо, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн салбарын хууль эрх зүйн орчин болон хөгжлийн бодлого төлөвлөлт, бодлогын чиглэлийг боловсронгуй болгох санал зөвлөмж, зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй



зохицуулалтын баримт бичиг болох дүрэм журам, нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, төлбөрийн хэмжээ, зохицуулалтын үйлчилгээний хэмжээ тогтоох, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн эрх зүйн актад дүн шинжилгээ, мониторинг хийснээр салбарын суурь хуулиуд, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай зэрэг холбогдох хууль тогтоомжид зохицуулалтын баримт бичгүүдийг нийцүүлэн шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн тухай зэрэг асуудлыг боловсруулан Хорооны хуралдаанаар тогтоол шийдвэрийг батлан хэрэгжүүлж ажилласан.

ХДЗХЯ-наас ирүүлсэн ХХЗХ-ноос захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн, бусад баталсан тогтоол шийдвэрийн талаар судалгааг ирүүлсэн загварын дагуу боловсруулж, Даргын 2024 оны 06 дугаар сар, 12 дугаар сарын эцсийн байдлаар нэгтгэн албан тоотоор хүргүүлэв.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу 2024 онд ХХЗХ-ны хуралдаанаар баталж, ХЗХДЯ-аар хянуулан бүртгүүлсэн, нэмэлт өөрчлөлт хөдөлгөөн хийсэн, хасуулсан нийт 6 хорооны тогтоолыг хавсралтын хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулан ажилласан. Үүнд:

- Хорооны 2024 оны 13 тоот тогтоол: “Шуудангийн илгээмж хүргэх хугацаа”-нд өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №6270: Хорооны 2023 оны 57 тоот тогтоол);
- Хорооны 2024 оны 33 тоот тогтоол: “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5060: Хорооны 2021 оны 02 дугаар тогтоол);
- Хорооны 2024 оны 42 тоот тогтоол: Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай ХХЗХ, СЕХ-ны хамтарсан 2020 оны 18/22 дугаар хамтарсан тогтоол;
- Хорооны 2024 оны 11, 14, 56, 58, 115, 117, 118, 118, 120, 122, 133 тоот тогтоолууд: Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай, баримт бичиг батлах тухай;
- Хорооны 2024 оны 43, 116, 144, 145, 146, 147, 148, 149, 157 тоот тогтоолууд: Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох, зөвшөөрөл олгох тухай;
- Хорооны 2024 оны 12 тоот тогтоол: Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2023 оны 155 тоот тогтоол);
- Хорооны 2024 оны 57 тоот тогтоол: Үндсэн хөрөнгө дахин үнэлэх, актлах тухай;
- Хорооны 2024 оны 121 тоот тогтоол: Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэх тухай;
- Хорооны 2024 оны 129 тоот тогтоол: Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай;
- Хорооны 2024 оны 130 тоот тогтоол: Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2024 оны 129 тоот тогтоол)
- Хорооны 2024 оны 143 тоот тогтоол: “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Интернэтийн үйлчилгээнд)”-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6907);



- Хорооны 2024 оны 170 тоот тогтоол: “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6945);
- Хорооны 2024 оны 186 тоот тогтоол: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэх тухай
- Хорооны 2024 оны 190 тоот тогтоол: Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай (Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль)
- Хорооны 2024 оны 203 тоот тогтоол: “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №6120: Хорооны 2022 оны 61 тоот тогтоол)
- Хорооны 2024 оны 242 тоот тогтоол: “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ыг шинэчлэн батлах (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №7054);
- Хорооны 2024 оны 258 тоот тогтоол: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, акталж данснаас хасах тухай зэрэг болно.

Тайлангийн хугацаанд буюу 2024 оны жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ны 2024 оны ээлжит, ээлжит бус 30 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийтдээ 146 асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны хуралдаанаас баталсан 263 тогтоол шийдвэр болон 14 удаагийн хуралдааны тэмдэглэл баталсан бөгөөд хорооны хуралдааны шийдвэрийг хуралдаан бүрээр тоймлон үзүүлбэл (<https://www.crc.gov.mn/documents/hhzh-togtool/mn?orderby=date&orderdir=desc&perpage=10>):

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар /2024-01-11/ Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2023 оны 155 тоот тогтоол: “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт); “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт” зарлах тухай; Хорооны хуралдааны удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх тухай (Тэмдэглэлийн төсөл) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 12 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр (Тогтоол №01-12, Хуралдааны тэмдэглэл-№01, 2024-01-11) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
2. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар /2024-01-18/ Хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2023 оны 57 тоот тогтоол: “Шуудангийн илгээмж хүргэх хугацаа”); “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио



- давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын баримт бичгийн төслийн тухай; Хорооны хуралдаанаар 2023 онд баталсан тусгай зөвшөөрлийн тухай тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар танилцуулга; Жи мобайл компанитай холбоотой дугаарлалтын төлбөрийн шүүхийн маргааны тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 9 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр (Тогтоол №12-21, Хуралдааны тэмдэглэл-№02, 2024-01-18) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
3. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар /2024-02-07/ Харилцаа холбооны зохицуулах хороонд 2023 онд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга (Хорооны 2023 оны жилийн эцсийн байдлаар); "ХХЗХ-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн найдваргүй авлагын хасагдуулга хийх тухай" танилцуулга (Хорооны 2023 оны 05 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад асуудал (ХХЗХ-ны анхны дарга асан Ч.Энхмэндийн өргөдөл, хүсэлтийн тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 11 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 3 тэмдэглэлээр (Тогтоол №22-32, Хуралдааны тэмдэглэл-№03-05, 2024-02-07) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
4. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар /2024-02-22/ УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийн тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам"-ын төслийн тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); "Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглах хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын зохицуулалтын хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай-Хуралдааны тэмдэглэлийн төсөл) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 9 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 3 тэмдэглэлээр (Тогтоол №32-41, Хуралдааны тэмдэглэл-№06-08, 2024-02-22) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
5. ХХЗХ-ны 2024 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар /2024-03-13/ "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын үнэлгээний хэсгийн дүгнэлтийн тухай (Хорооны 2024 оны 14 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (Хорооны 2024 оны 07 дугаар хуралдааны Тэмдэглэл); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах,



- хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 8 тогтоолыг (Тогтоол №42-49, 2024-03-13) батлан шийдвэрлэв.
6. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар /2024-03-15/ Тусгай зөвшөөрөл олгох тухай (Хорооны 2024 оны 43 тоот тогтоолын хэрэгжилт); Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай (Телевизийн газрын дахин дамжуулах сүлжээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 7 (Тогтоол №50-56, 2024-03-15) тогтоолыг батлав.
 7. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар /2024-03-29/ “Телевизийн газрын дахин дамжуулах сүлжээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг” -ийн төслийн тухай (Хорооны 2024 оны 56 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2023 оны үндсэн статистик үзүүлэлтүүд” болон ОУЦХБ-ын (ITU-IDI) индексийн талаар танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хорооны эд хөрөнгийн 2023 оны тооллогын тайлангийн тухай танилцуулга (Хөрөнгө дахин үнэлэх, актлах тухай); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 13 (Тогтоол №57-69, 2024-03-29) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.
 8. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар /2024-04-17/ ХХЗХ-ноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын тоог тогтоох тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Монкаст радио ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 15 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр (Тогтоол №85-100, Хуралдааны тэмдэглэл-№09, 2024-04-17) хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
 9. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар /2024-04-30/ “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага /интернэтийн үйлчилгээнд/”-ыг шинэчлэн батлах тухай; Монгол Улс болон ОХУ-ын хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалт, уулзалтын үр дүнгийн тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 16 (Тогтоол №57-69, 2024-04-30) тогтоолыг баталсан болно.
 10. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар /2024-05-16/ ХХЗХ-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын гүйцэтгэл, санал дүгнэлтийн тухай; ХХЗХ-ноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай; “Орхон аймгийн Баян-



- Өндөр суманд радиогийн өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт” зарлах тухай; Телевизийн газрын дахин дамжуулах сүлжээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох” (ХХЗХ-2024/DTV-01) сонгон шалгаруулалтын үнэлгээний дүнгийн тухай; Дараа үеийн хөдөлгөөнт холбоонд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 20 (Тогтоол №101-120, 2024-05-16) тогтоолыг баталж шийдвэрлэсэн болно;
11. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар /2024-05-29/ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46.9-д заасны дагуу “Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр мэдэгдэл ирүүлж, бүртгүүлсэн эрх бүхий радио, телевизийн жагсаалт” батлах тухай; “Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах ТЗ олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг” батлах тухай (Хорооны 2024 оны 115 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Радио давтамжийн 2575-2595 МГц-ийн 20 МГц болон 2595-2615 МГц-ийн 20МГц зурвасыг ДҮХХ-ны системд ашиглах ТЗ олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг” батлах тухай (Хорооны 2024 оны 119, 120 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Тогтоол хүчингүй болгох тухай (Хорооны 2024 оны 117 тоот, 118 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, шилжүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 8 (Тогтоол №121-128, 2024-05-29) тогтоолыг батлав.
12. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар /2024-06-02/ “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай” асуудлыг хэлэлцэн нийт хорооны 1 (Тогтоол №129, 2024-06-02) тогтоолыг баталсан. Монгол Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 42 бие даан нэр дэвшигч, 21 нам эвсэл болон ЦХХХЯ, ШӨХТГ зэрэг холбогдох яам_ байгууллагуудад албажуулан 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн (03/903) албан тоотоор хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
13. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар /2024-06-08/ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 129 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэн нийт хорооны 1 (Тогтоол №130, 2024-06-08) тогтоолыг батлан шийдвэрлэв. Нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоолыг 2 хавсралтыг хамт Монгол Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 42 бие даан нэр дэвшигч, 21 нам эвсэл болон ЦХХХЯ, ШӨХТГ зэрэг холбогдох яам_ байгууллагуудад албажуулан 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн (03/904-



- 949) албан тоотоор хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
14. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар /2024-06-11/ Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох тухай (Хорооны 2024 оны 116 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Монгол Улс болон БНХАУ-ын хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалт, уулзалтын үр дүнгийн тухай танилцуулга; Радио долгионы хяналт, шалгалттай холбоотой 2024 онд хийгдсэн ажлын танилцуулга; Радио давтамжийн 2575-2595 МГц болон 2595-2615 МГц-ийн зурвасыг ДҮХХ-ны системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг батлах тухай (Хорооны 2024 оны 119, 120 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 117, 118 дугаар тогтоолыг тус тус цуцлах, сонгон шалгаруулалт зарлах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 6 (Тогтоол №131-136, 2024-06-11) тогтоолыг баталсан болно.
15. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар /2024-06-14/ “Интернэтийн үйлчилгээний нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах төсөлд ирүүлсэн саналын талаар танилцуулга; Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд цахим орчинд хэрэгжүүлж буй хяналтын ажлын явцын танилцуулга; Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны хяналтын явцын танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 6 (Тогтоол №137-142, 2024-06-14) тогтоолыг баталсан.
16. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 16 дугаар хуралдаанаар /2024-06-27/ “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага /интернэтийн үйлчилгээнд/”-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2020 оны 23 тоот тогтоолын 2 дугаар хавсралт); “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох” 2024/01 дугаартай нээлттэй сонгон шалгаруулалтын тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2024 оны 114 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 14 (Тогтоол №143-156, 2024-06-27) тогтоолыг батлан шийдвэрлэсэн;
17. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 17 дугаар хуралдаанаар /2024-07-09/ Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналтын тайлан, үр дүнгийн тухай танилцуулга; Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд цахим орчинд хэрэгжүүлсэн хяналтын ажлын тайлан, үр дүнгийн тухай танилцуулга; “Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн



- дүгнэлтийн тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 7 (Тогтоол №157-163, 2024-07-09) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
18. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 18 дугаар хуралдаанаар /2024-07-31/ Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 7 (Тогтоол №164-169, 2024-07-31) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
19. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар /2024-08-15/ Радио телевизийн хөтөлбөрийн мониторингийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан, санал дүгнэлтийн талаар танилцуулга; ХХЗХ-ноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай; ХХЗХ-ны 2024 оны 117 тоот болон 118 тоот тогтоол, “Радио давтамжийн 2540-2550 МГц/2660-2670 МГц, 2550-2555 МГц/2670-2675 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны (4G/LTE) системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын баримт бичиг батлах тухай; ХХЗХ-ны 2024 оны эхний хагас жилийн тооллогын тайлан, хөрөнгө актлах саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 10 (Тогтоол №170-180, 2024-08-15) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
20. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 20 дугаар хуралдаанаар /2024-08-30/ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-д заасан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төслийн танилцуулга (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-д заасан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); ХХЗХ-ноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай (Хорооны 2024 оны 09 дүгээр Хуралдааны Тэмдэглэлийг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн тус Хорооны зохицуулах хорооны 5 (Тогтоол №181-185, 2024-08-30) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно. Түүнчлэн тус хуралдааны 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам” /Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль/-ийн төслийн тухай 10 дугаар хуралдааны Тэмдэглэл; “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам” /Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль/- шинэчилсэн найруулгын төслийн тухай 11 дүгээр хуралдааны Тэмдэглэлийг тус тус баталж, холбогдох ажлын алба, газрын



- удирдлагад журмын төслийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах талаар удирдамж, чиглэлийг баримтлан ажиллахыг үүрэг болгов.
21. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 21 дүгээр хуралдаанаар /2024-09-11/ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-д заасан “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэх тухай” (Тогтоолын төсөл); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 3 (Тогтоол №186-188, 2024-09-11) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно. Энэхүү хуралдаанаар баталсан “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэх тухай” 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 186 тоот тогтоолыг хавсралтыг хамт Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нийтдээ 21 нам эвсэл болон СЕХ, МҮОНРТВ, ЦХХХЯ, ШӨХТГ, ЦЕГ зэрэг холбогдох яам, байгууллагуудад 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн (03/1664) албан тоотоор албажуулан хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулан хэрэгжилтэд хяналт тавьж, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажилласан.
22. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 22 дугаар хуралдаанаар /2024-09-17/ Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамрах хүрээнд “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт” зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичиг батлах тухай (Хорооны 2024 оны 181 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай (Тогтоолын төсөл); Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2024 оны эхний хагас жилийн статистик, үндсэн үзүүлэлтийн тайлангийн танилцуулга; ХХЗХ-нд 2024 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлангийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тогтоолд өөрчлөлт оруулах тухай: Хорооны 2024 оны 157 тоот тогтоол) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 6 (Тогтоол №189-194, 2024-09-17) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно. Энэхүү хуралдаанаар баталсан “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай” (Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль) 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 190 тоот тогтоолыг хавсралтыг хамт Тогтоолыг хавсралтыг хамт Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 11 нам эвсэл болон СЕХ, МҮОНРТВ, ЦХХХЯ, ШӨХТГ, ЦЕГ зэрэг холбогдох яам, байгууллагуудад 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн (03/1698) албан тоотоор албажуулан хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулсан болно. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст



- байршуулан хэрэгжилтэд хяналт тавьж, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллав.
23. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 23 дугаар хуралдаанаар /2024-09-30/ “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; Санхүүгийн бүртгэлд залруулга хийх тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай-Ажлын хэсгийн санал дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 8 (Тогтоол №195-202, 2024-09-30) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
24. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 24 дүгээр хуралдаанаар /2024-10-15/ “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2022 оны 61 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай шинээр зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 7 (Тогтоол №203-209, 2024-10-15) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
25. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар /2024-10-30/ Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт, саналын тухай (Хорооны 2024 оны 189 тоот тогтоолын хэрэгжилт); ХХЗХ-ноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох тухай; Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр цахим орчин болон радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажилласан тайлангийн танилцуулга (Хорооны 2024 оны 186 тоот, 190 тоот тогтоолын хэрэгжилт); ХХЗХ-ны хуралдаанаар 2023-2024 онд баталсан тусгай зөвшөөрлийн тухай (олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах) тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай; ХХЗХ-ны дэргэдэх РДӨНХТ-ийн хашаанд байрлах Юнител ХХК-ийн барилгын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай шинээр зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт;) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 9 (Тогтоол №210-218, 2024-10-30) тогтоолыг батлан шийдвэрлэв. Тус хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр (Тэмдэглэл-12, 2024-10-30) хугацаатай удирдамж чиглэл өгөхөөр тогтов.
26. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 26 дугаар хуралдаанаар /2024-11-14/ “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2023 оны хуралдааны 07 дугаар Тэмдэглэлийг хэрэгжүүлэх); “Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгийн нутаг Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох” Нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг батлах тухай (Хорооны 2024 оны 211 тоот тогтоол); ХХЗХ-ны 2024 оны санхүүгийн тайлангийн зардлын шинжилгээ, төсвийн гүйцэтгэлийн



- танилцуулга (2024 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад: Юнител ХХК-иас ирүүлсэн албан тоотын тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 13 (Тогтоол №219-231, 2024-11-14) тогтоолыг батлан шийдвэрлэж, тус хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр (Тэмдэглэл-12, 2024-10-30) хугацаатай удирдамж чиглэл өгөхөөр тогтов.
27. Харилцаа холбооны рохицуулах хорооны 2024 оны ээлжит 27 дугаар хуралдаанаар /2024-11-29/ ГЕГ-ын Хяналт бүрдүүлэлтийн газар, Гаалийн цахим систем, Гаалийн хяналтын бүсийн талаар танилцуулга (Хорооны 2024 оны ээлжит 23 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт); Хорооны хуралдааны 2024 оны 13 дугаар Тэмдэглэлийн хэрэгжилтийн тухай танилцуулга (Юнител ХХК-иас ирүүлсэн албан тоотын тухай); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Сүлжээний дугаарлалтаас хэсэгчлэн буцаах талаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх саналын тухай); “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2026-2027 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай”-Анхны хэлэлцүүлэг. (Үүнд: ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2025 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2025 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2025 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026-2027 оны төсвийн төсөөлөл”-ийн төсөл) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 9 (Тогтоол №232-240, 2024-11-29) тогтоолыг батлан шийдвэрлэв.
28. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар /2024-12-05/ Мобинет ХХК, Юнивишн ХХК, Скаймедиа Корпораци ХХК, Ондо ХХК-иас ирүүлсэн “Радио давтамжийн зурвасыг ДҮХХ-ны 4G/LTE системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-т өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, хугацааг хойшлуулах тухай гомдол, хүсэлтийн тухай асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 1 (Тогтоол №241, 2024-12-05) тогтоолыг батлан шийдвэрлэв.
29. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 28 дугаар хуралдаанаар /2024-12-16/ “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2024 оны ээлжит 26 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх); “Монгол шуудан” ХК-ийн давамгайл байдлтай үйлчилгээний тарифын дээд хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулах; ХХЗХ-ны 2013 оны 55 тоот тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгох тухай; “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2026-2027 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай”-2 дугаар хэлэлцүүлэг. (Үүнд: ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2025 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2025 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2025 оны хөтөлбөр,



арга хэмжээний зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2026-2027 оны төсвийн төсөөлөл"ийн төсөл) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №242-252, 2024-12-16) тогтоолыг батлан шийдвэрлэв.

30. Зохицуулах хорооны 2024 оны ээлжит 29 дүгээр хуралдаанаар /2024-12-27/ Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох "АрР-Орон нутаг 2024/02" нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт, саналын тухай (Хорооны 2024 оны 219 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); ХХЗХ-ны "Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн 2024 оны ажлын тайлан"-гийн танилцуулга; Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн олгох, хугацаа хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №253-263, 2024-12-27) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Хорооны хуралдаанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар баталсан тогтоол, шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн тайланг нэгтгэн хавсаргав (Хавсралт-01).

2024 оны жилийн эцсийн байдлаар, Хорооны 2024 оны хуралдааны тогтоолоор шинэчлэн баталсан, шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм, журам, техникийн болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, өрсөлдөөний журам, үнэ тариф төлбөрийн хэмжээ, радио давтамжийн зохицуулалт, хуваарилалт зэрэг зохицуулалтын баримт бичгийг ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлж шийдвэрлэсэнтэй холбогдуулан тус хорооны ХХЗХ, СЕХ-ны хамтарсан 2020 оны 18/22 дугаар хамтарсан тогтоол (Хорооны 2024 оны 42 тоот тогтоол); 2020 оны 23 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтыг; Хорооны 2019 оны 20 тоот тогтоол; Хорооны 2024 оны 117 тоот тогтоол, 118 тоот тогтоол, 119 тоот тогтоол, 120 тоот тогтоол болон 2024 оны 132 тоот тогтоол, 133 тоот тогтоол, 171 тоот тогтоол, 172 тоот тогтоол; Хорооны 2020 оны 35 тоот тогтоол, 2022 оны 17 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов.

Зөвшөөрлийн тухай хуулийг хугацаанд нь хэрэгжүүлэх зорилгоор ТЗ-ийн талаар гаргасан үнэлгээ, дүгнэлтийг Хорооны хуралдаанд хугацаа алдахгүй хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлэхийг ХХЗХ-ны 2024 оны ээлжит 17 дугаар хуралдааны протоколоор ТЗ-ийн материалыг тухай бүр хүргүүлэх асуудлыг судлан "Хорооны хуралдааны дэг"-д 2024 оны 3 дугаар улиралд багтаан хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон. Энэхүү үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Хорооны 2024 оны ээлжит 26 дугаар хуралдаанд "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 93 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-ийн 2 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан хэлэлцүүлж, 2024 оны 195 тоот "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолыг батлуулан шийдвэрлэв.



ХХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хуралдсан Хорооны ээлжит 26 дугаар хуралдааны протоколоор “Хорооны хуралдааны дэг”-д Хорооны гишүүдийн нэр зааж ирүүлсэн болон “гарт нь” гэсэн албан тоот бичгээр болон биеэр хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн хүсэлт, санал гомдол зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх зохицуулалт; Хорооны хуралдааныг хаалттай зохион байгуулах, асуудлыг хаалттай хэлэлцэх, ямар асуудал хэлэлцэх, шийдвэрийг албажуулах зохицуулалт; Хорооны хуралдааны үеэр дарга, гишүүдийн гаргасан санал, үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах асуудлыг боловсруулан Хорооны 2024 оны ээлжит 28 дугаар, ээлжит 29 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Хорооны хуралдааны үеэр Хорооны дарга, гишүүдээс гарсан тухайн асуудлаар газар, бүтцийн нэгж, удирдлагад удирдамж чиглэл, хугацаатай үүрэг даалгавар болон гишүүнээс гарсан санал, үүрэг чиглэлийг хурлын тэмдэглэлд тусгаж, өгсөн үүрэг даалгавар, саналын судалгааг (Хуралдааны огноо, Хэлэлцсэн асуудал болон Дарга, гишүүний нэр, агуулга, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах газар, шийдвэрлэсэн байдал) шинэчилсэн загварын дагуу гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж тухай бүр тайлагнан ажиллаж байна.

Зохицуулах хорооны ээлжит, ээлжит бус хуралдааныг нийт 30 удаа зохион байгуулж, хуралдааны үйл ажиллагааны зардалд гүйцэтгэлээр нийт 394.2 сая төгрөгийг (гүйцэтгэл 100 хувь) зарцуулан ажилласан байна. Үүнээс: Хорооны хуралдааны цалин хөлс 216.6 сая төгрөг, байгууллагаас төлсөн НДШ АО-ийн шимтгэлд 27.1 сая төгрөг, НДШ-д 24.11 сая төгрөг, ХХАОТ-д 19.25 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хорооны 2024 оны ээлжит 30 удаагийн ээлжит, ээлжит бус хуралдааны мэдээний төслийг боловсруулж, баталсан тогтоол шийдвэр, тэмдэглэлийг албажуулах, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлсэн 2024 оны 6 тогтоол (2024 он: Тогтоол-13, Тогтоол-33, Тогтоол-143, Тогтоол-170, Тогтоол-203, Тогтоол-242) хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.csg.gov.mn)-д тус тус байршуулан олон нийт, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт ил тод, нээлттэй, цахимаар авах боломжийг бүрдүүлэв.

ХХЗХ-ноос “Сүлжээ ба интернэтийн замчлал” технологийн сургалтыг 2024 оны 3 дугаар сард зохион байгуулж, уг сургалтад төрийн байгууллага, интернэт, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон банкны дата төв зэрэг нийт 26 байгууллагын 55 инженер, техникийн албан хаагчдыг хамруулсав.

Монгол Улсын интернэтийн дундын холболтын өнөөгийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлага, бодлого зохицуулалт, тэргүүн туршлага солилцох зорилго бүхий “IPv6, IXP, Datacenter” сэдэвт форумыг 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Уг форумд мэдээллийн сүлжээний зохицуулалт, мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын талаар танилцуулж, хэлэлцүүлсэн. Энэхүү хэлэлцүүлэг болон үйлчилгээ эрхлэгчдийн санал хүсэлтийн дагуу мэдээллийн сүлжээний зохицуулалтын чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах ажлын хэсгийг



байгуулж ажиллахаар тогтож, Зохицуулалтын газраас ажлын хэсгийг байгуулсан. (ХХЗХ-ны даргын 2024.03.15-ны өдрийн А/67 тоот тушаал).

ЦХХХЯ, ХХААХҮЯ болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран "Охидын манлайлал" өдөрлөгийг 2024 оны 4 дүгээр сард зохион байгуулсан. Өдөрлөгт ШУТИС-ийн Мэдээлэл, холбоо технологийн сургууль болон Хөдөө аж ахуйн их сургуулийн 1-3 дугаар курсийн 80 гаруй эмэгтэй оюутан болон холбогдох төрийн болон олон улсын 20 гаруй байгууллагын 100 гаруй төлөөлөл оролцсон. Арга хэмжээний тайлан, мэдээллийг ОУЦХБ-д хүргүүлсэн.

Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, цахим худалдаа болон шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, боломж, төрөөс үзүүлэх дэмжлэг зэрэг асуудлаар санал бодлоо солилцож, шийдэл боломжийн талаар хэлэлцэх зорилгоор "Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг" хэлэлцүүлгийг 2024 оны 6-р сарын 4-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ЦХХХЯ, ГХЯ, ХХЗХ, Монгол банк, ГЕГ, ТЕГ, УХШИГГ, "И-Монголиа" УТҮГ, "Улс хоорондын шуудангийн холбоо" ТББ мөн "Монгол инфинити шуудан" ХХК, "Эс Эф Эм Эл" ХХК, "Пик пак ворлдвайд" ХХК, "Стора централ" ХХК, "Альфа лабс" ХХК зэрэг цахим худалдаа, цахим платформ, хүргэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компаниуд болон төрийн байгууллагын 100 орчим төлөөлөл оролцов. Мөн "Эс Эф Эм Эл" ХХК-ийн БНХАУ дахь хамтран ажиллагч байгууллагын төлөөллүүд хүрэлцэн ирж, илтгэл танилцуулсан. Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг сэдвийн хүрээнд боломж, асуудал, гарц шийдлүүдийг агуулсан дараах илтгэлүүдийг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж батлав.

Монгол Улсад сансрын технологийг хөгжүүлэх, хиймэл дагуулын хэрэглээг нутагшуулах хэрэгцээ шаардлагын талаар сансрын холбоо, тандан судалгааны хиймэл дагуулын хэрэглэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, судлаач, эрдэмтдийн оролцсон хэлэлцүүлгийг 2024 оны 10 сарын 24-ний өдөр ШУТИС-ийн төв байранд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт харилцаа холбооны болон зайнаас тандан судлалын хиймэл дагуулыг үйл ажиллагаандаа ашигладаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл, шинжлэх ухааны академи, их, дээд сургууль, төрийн бус байгууллагын эрдэмтэн судлаачид зэрэг 30 орчим байгууллагын 150 гаруй төлөөлөгч оролцсон бөгөөд хэлэлцүүлгээс зөвлөмж гаргаж Сансрын бодлогын үндэсний зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

ХХЗХ-ноос шуудангийн салбарт тулгамдаж буй асуудлуудын хүрээнд "Шуудангийн салбарын зохицуулалт-2024" зөвлөгөөнийг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулав. Зөвлөгөөнд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Монгол шуудан ХК, Монгол Инфинити шуудан ХХК, Түгээмэл шуурхай шуудан ХХК, ВИПМК ХХК, Эс эф экспресс олон улсын буухиа шуудан, Юбикаб ХХК, Дөлгөөн дэлгэрэх ХХК, Юбикаб экспресс ХХК, Монголиан смарт дрон деливери ХХК, Улс хоорондын шуудан илгээмжийн холбоо ТББ, what3words болон шуудангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөлөл оролцлоо. "Шуудангийн салбарын



зохицуулалт-2024” зөвлөгөөний хүрээнд үндсэн дөрвөн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, тухайн чиглэлээр бодлого боловсруулдаг төрийн байгууллага, холбоод, хувийн хэвшлийн төлөөлөгчид бодит амьдралд тохиолдож байгаа ололттой болон алдаа дутагдалтай талуудыг харилцан туршлага судалж, санал шийдэл, сайжруулах боломжуудыг хэлэлцэн зөвлөмж гаргав.

ХХЗХ-ноос жил бүр зохион байгуулдаг “Зохицуулалт-2024” арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр амжилттай зохион байгуулж, арга хэмжээнд Cullen International олон улсын судалгааны байгууллагын Захирал ноён Philippe Defraigne хүрэлцэн ирж “Цахим үйлчилгээний хууль (DSA), Цахим худалдааны хууль (DMA) болон хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн сүлжээний харилцан холболтын зохицуулалт”-ын талаар танилцуулж, илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд хэлэлцүүлэгт 38 байгууллагын 80 гаруй төлөөлөл оролцсон салбар хоорондын зохицуулалтын хамтын ажиллагааг уялдуулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн мониторинг, хяналт шалгалт, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт: Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Харилцаа холбооны тухай” хуулийн 8.1 зүйл, 9.1.3 зүйл (Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих); “Радио долгионы тухай” хуулийн 5¹.1.4 (Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх), 5¹.1.7 (цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих), 20.1 (Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Зохицуулах хороо болон харилцаа холбооны улсын байцаагч хэрэгжүүлнэ); “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль; “Зөрчлийн тухай” хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн өргөн нэвтрүүлгийн суурин, явуулын хяналт мониторинг хийх, хэрэглэгчийн төхөөрөмж баталгаажуулах, цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх, дүгнэлт гаргах, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийх, улсын байцаагчийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хэрэглэгчид, эрхийн бичиг эзэмшигчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн албан хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хэлбэрээр болон хорооны тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу, төлөвлөгөөт хэлбэрээр радио давтамжийн дараах хэмжилт, хяналт, шалгалтуудыг хийж, холбогдох хууль, журам, техникийн нөхцөл шаардлагын хүрээнд дүгнэлт гарган, шийдвэрлэн ажилласан. ХХЗХ-ны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв (РДӨНХТ) нь 2024 оны жилийн эцсийн байдлаар, албан тоот хүсэлтээр хөдөө орон нутагт 9, Улаанбаатар хотод 25, нийт 34 байршилд радио давтамжтай цахилгаан соронзон орноос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилтийг хийж, дүгнэлт гаргасан ба 79 албан бичгээр хөдөө орон нутагт 36, Улаанбаатар хотод 61 байршил, нийт 97 байршилд радио давтамжийн зурваст үүссэн харилцан нөлөөллийн хэмжилтийг хийж, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулан ажилласан болно.



ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний заалт, төлөвлөгөөт болон эрх бүхий байгууллага, иргэн, ААН-н хүсэлтээр РДӨНХТ-ийн харилцаа холбооны улсын байцаагч, инженер, техникийн ажилтнууд 2024 онд Монгол улсын 21 аймаг, 37 сум, хилийн 5 боомтод хэмжилт, хяналт шалгалт, нийтдээ албан томилолтоор ажлын 102 хоногийн хугацаатай ажиллаж, нийтдээ 23,4 мянган км замыг туулж хэмжилт, хяналт хийж гүйцэтгэсэн байна.

Тус хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд “Радио давтамжийн харилцан нөлөөлөл ба хууль бус хэрэглээ” “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалт” сэдвээр сургалт 2024 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус 2 өдрийн сургалтад Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын байцаагч нар болон Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0101, Хилийн цэргийн 0243-р ангийн алба хаагчид хамрагдаж, мэрэгжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

2024 оны 04 дүгээр сард Дархан-Уул, Орхон, Булган аймгийн төвүүдэд радио долгионы өргөн зурвасын хэмжилт хийх, радио давтамжийн ашиглалтын байдлыг тодорхойлох, радио давтамжийн тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хууль бус хэрэглээг илрүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллав. Түүнчлэн Булган, Төв, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа 67 аж ахуйн нэгж тус хэмжилт, хяналтад хамрагдлаа.

Монгол Улс болон БНХАУ-ын харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хооронд хил орчимд ашиглах радио давтамжийн зохицуулалтын уулзалт, тус уулзалтаар тохирсон асуудлаар ХХЗХ-ноос хилийн боомтуудад томилолтоор ажлын хэсгүүд томилон ажиллуулж, хэмжилтийн тайланг холбогдох талуудад хүргүүлэн ажиллав. Үүнд: Дорнод аймгийн Чойбалсан сумын Хавирга хилийн боомтод; Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын хилийн боомт болон Хүдэр сумын хилийн заставын орчимд; Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомт; Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомт; Дорнод аймгийн Халх гол сумын Сүмбэр хилийн боомт; Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумын Гашуун сухайт хилийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд, Ханги боомтууд болно.

Ажлын хэсгээс үүрэн холбооны операторуудын 4G/LTE үйлчилгээнд хийсэн хэмжилтийн дүнгээр хамрах хүрээний зураглал, тайланг боловсруулан гаргасан. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээний чанар, хамрах хүрээний хэмжилтийг хийж гүйцэтгэж, хэмжилтийн тайланг ХХЗХ-ны Даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар, 25 дугаар хуралд хэлэлцүүлж, тайлан мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээг авч ажиллав.

Монгол улсын зах зээлд нэвтэрсэн болон нийлүүлэгдэх мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг (харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмж) холбогдох хууль эрх зүй, баримт бичгийн хүрээнд баталгаажуулж тохирлын гэрчилгээ олгох хүрээнд 2024 оны жилийн эцсийн



байдлаар, тус хорооны дэргэдэх Баталгаажуулалтын зөвлөлийн 22 удаагийн хурлаар баталгаажуулалтын шинээр олгох 254, сунгалт хийлгэх 220, нийт 474 ш төхөөрөмжүүдийн баримт бичигт үнэлгээг гүйцэтгэж, дүгнэлтийг хэлэлцүүлж, Хорооны даргын тушаалаар шийдвэрлүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд буюу жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ноос радио давтамжийн эрхийн бичгийн хүсэлт санал, ирүүлснээс нийт 191 дүгнэлт гаргаж, шинээр 78, сунгалтаар 98, өөрчлөлт оруулсан 9, цуцлах 6 эрхийн бичгийг шийдвэрлэв.

Тайлант хугацаанд Радио давтамж ашиглах эрхийн бичгийн 164, тусгай дугаарын бүртгэлийн гэрчилгээний 39, веб сайтын бүртгэлийн гэрчилгээний 20 хүсэлтийг хүлээн авч, дүгнэлтийг нэгтгэж танилцуулж, Хорооны даргын тушаалаар шийдвэрлүүлж, бүртгэлийн гэрчилгээ олгов.

Тус хороонд баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн нийт 237 хүсэлтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж Даргын тушаалаар олгоод (шинэ-146, сунгалт-90, өөрчлөх-1) байна.

Радио давтамжийн харилцан нөлөөллийн чиглэлээр 41 албан бичиг, хүсэлт ирсэн ба хэмжилт, томилолтоор нийт 7 аймаг орон нутагт 18 байршилд, Улаанбаатар хотод 31 харилцан нөлөөллийн гомдлыг шалгаж шийдвэрлэсэн, Түүнчлэн Цахилгаан соронзон орны хүний биед нөлөөлөх нөлөөллийн хэмжилт дүгнэлтийг хот, орон нутагт нийт 5 удаа гарган шийдвэрлэсэн байна.

Радио долгионы хяналтын үйл ажиллагаанд “MNS ISO/IEC 17020:2013–төхирлын үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага” стандартыг баримтлан Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвд итгэмжлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Суурин хяналт, шалгалтын хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа РӨН-ийн үйлчилгээ эрхлэгчдийн дохионы зөөгч давтамжийн хазайлт, төвийн давтамжийн шилжилт, эзэлсэн зурвасын өргөн зэрэг үндсэн үзүүлэлтүүд стандартын шаардлага хангаж байгаа эсэх хэмжилтийг өдөр тутам тогтмол хийж ажилласан ба хэмжилтийг нэг РӨН-ийн үйлчилгээ эрхлэгчийг өдөрт 50 удаа хэмжиж 7 хоног бүр 8500 удаагийн хэмжилтийн утгыг цаашдын үйл ажиллагаа, судалгаанд зориулан архивлан хадгалж ажиллав. Хэмжилтийн дүнг нэгтгэн боловсруулж хэмжилтийн тайланг 12 удаа байгууллагын цахим хуудсанд байршуулан хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт мэдээллийг ил тод байдлыг ханган ажиллав. Түүнчлэн Суурин хяналт, шалгалтын хүрээнд тус хорооноос FM РӨН-ийн дахин дамжуулах радио станцын давтамж болон үндсэн радио станцын давтамж хооронд интермодуляц үүссэн 7 тохиолдлыг суурин хяналтаар илрүүлсэн ба холбогдох FM РӨН-ийн үйлчилгээ эрхлэгчдэд илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөрчил арилгах тухай албан бичиг хүргүүлж зөрчлийг арилгаж ажилласан.

ХХЗХ нь 2024 онд, радио давтамжийн эрхийн бичгийн хугацаа дууссан нийт 39 байгууллагын 58 радио давтамжид хэрэглээ, ашиглалт байгаа эсэх хяналтыг суурин хяналтын станцаар хийж гүйцэтгэв. Хэмжилтийн дүнг тухай бүр эрхийн бичиг



хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж холбогдох арга хэмжээг авч ажиллав. Мөн суурин хяналтын станцаар хэрэглээ, ашиглалт илэрсэн 26 хуулийн этгээдэд мэдэгдэл хүргүүлэн, зөрчил дутагдлыг хугацаанд арилгуулан хамтран ажилласан.

Эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хүрээнд харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчид, аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм, журам, нөхцөл, шаардлагын талаар утсаар, уулзалтаар, цахим шуудангаар 120 гаруй иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт: ХХЗХ-ны 2024 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹.1.11, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх асуудлын талаарх танилцуулгыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2024 онд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтыг Улаанбаатар хотод зарлах шаардлагагүй гэж тогтов. Харин радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байхгүй аймагт үйлчилгээ эрхлэх эрэлт, хэрэгцээ үүссэн эсхүл аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх, радио, давтамж ашиглахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд тухайн нэр бүхий аймагт 2024 онд сонгон шалгаруулалтаар олгох радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх асуудлыг холбогдох мэдээлэл, судалгааны хамт Хорооны хуралдаанд тухайн үед нь танилцуулж шийдвэрлүүлэх удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар /2024-02-22/ УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийн тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам"-ын төслийн тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); хэлэлцэж, СЕХ-д батлуулахаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар /2024-05-29/ Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46.9-д заасны дагуу "Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр мэдэгдэл ирүүлж, бүртгүүлсэн эрх бүхий радио, телевизийн жагсаалт" батлах тухай 2024 оны 121 тоот тогтоолыг батлуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар /2024-06-02/ "Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай" асуудлыг хэлэлцэн нийт хорооны 1 (Тогтоол №129, 2024-06-02) тогтоолыг



баталсан. Монгол Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 42 бие даан нэр дэвшигч, 21 нам эвсэл болон ЦХХХЯ, ШӨХТГ зэрэг холбогдох яам_ байгууллагуудад албажуулан 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн (03/903) албан тоотоор хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар /2024-06-08/ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 129 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэн нийт хорооны 1 (Тогтоол №130, 2024-06-08) тогтоолыг батлан шийдвэрлэв. Нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоолыг 2 хавсралтыг хамт Монгол Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 42 бие даан нэр дэвшигч, 21 нам эвсэл болон ЦХХХЯ, ШӨХТГ зэрэг холбогдох яам_ байгууллагуудад албажуулан 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн (03/904-949) албан тоотоор хүргүүлэв. Тогтоолыг хавсралтыг хамт СЕХ, МҮОНРТВ, ХХЗХ-ны цахим хуудаст байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдлын үнэлэлт дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=259>

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшил, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн 2024 оны хөдөлгөөний тоон мэдээлэл (шинээр олгосон, түдгэлзүүлсэн, өөрчлөлт орсон, хүчингүй болгосон, дуусгавар болсон)-ийг 2024 оны байдлаар нэгтгэн гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=259>

УБ, Орон нутгийн ӨНТВ болон АРТВ, ОСДҮЭ-дэд өөрийн болон оюуны өмчийн зөвшөөрөлтэй бүтээл, контентын мэдээллийг Copyright системд байршуулах талаар утсаар, мэйлээр болон сургалт семинараар тогтмол заавар, зөвлөгөө өгч, мэдэгдэл хүргүүлж ажилласан. 2024 оны 4-р улирлын байдлаар УБ хотын ӨНТВ 13/18, АТВ 10/49, Орон нутгийн ӨНТВ 11/45, АТВ 0/3, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 6/9, төлбөртэй телевизийн 0/16, нийт 40 үйлчилгээ эрхлэгч холбогдох мэдээллээ системд байршуулсан.

Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил, тод нээлттэй байршуулах дундын нэгдсэн системийн ашиглалтын байдлын талаар аналитик тайлан, дүгнэлт гаргаж, тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=142>

Монгол улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй телевизүүдийн нэвтрүүлсэн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн 2023 оны жилийн эцсийн төлөвлөгөөний



хэрэгжилтийн нэгдсэн хураангуй тайланг 2022 онтой харьцуулж гаргасан. Цахим хуудсаар мэдээлсэн, судалгааны хамт холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэн байна.

<https://www.crc.gov.mn/articles/televiz-dijn-dohiony-hel-hadmал-tajlbartaj-nevtr-leg-nevtr-lsen-bajdal-2023-ony-zhiliin-tajlan/mn>

Дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай телевизийн нэвтрүүлгийн 2024 оны эхний хагас жилийн тайланг ЦХИХХЯ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

<https://crc.gov.mn/articles/h-qzhliin-berhsheeltej-h-nij-medeelel-avah-erhiig-hangah-chigleleer-televiz-dijn-dohiony-hel-hadmал-tajlbartaj-nevtr-leg-nevtr-lsen-bajdal-2024-ony-hagas-zhil/mn>

УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшлийн талаарх холбогдох мэдээллийн лавлагааг авч тулгалт хийж, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг шинэчилж Хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=304>

Радио, телевизийн хөтөлбөрийн мониторингийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны 12-р сарын тайлан, мэдээллийг нэгтгэн боловсруулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <https://www.crc.gov.mn/pages/show/ub-hotyn-rg-n-nevtr-lgijn-televiz-2024-ony-monitoringijn-d-n>

<https://www.crc.gov.mn/pages/show/ub-hotyn-arilzhaany-televiz-2024-ony-monitoringijn-d-n>

<https://www.crc.gov.mn/pages/show/2024-ony-1-r-ulirlyn-monitoringijn-negdsen-d-n>

<https://crc.gov.mn/pages/show/ulaanbaatar-hotod-arilzhaany-radioijn-ijlchilgee-erhlegchdijn-h-t-lb-rijn-n-hc-l-shaardlagyn-bielelted-2024-ony-monitoringijn-d-n>

Гадаад сувгийн мэдээллийг олон сувгийн дамжуулах бүх үйлчилгээ эрхлэгчдээс хүлээн авч, хянаж, нэгтгэсэн. Гадаад сувгийн жагсаалтыг шинэчилж байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Радио, телевизээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн бүтээл үйлдвэрлэлд гарсан өөрчлөлтөд үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор ӨН-ийн 18 телевизийн 2022-2023 оны жилийн нэгдсэн тайланд анализ хийж, нэгтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Тусгай зөвшөөрөл, харилцаа холбооны сүлжээний дугаарын зөвшөөрлийн зохицуулалт: Зохицуулах хороо нь 2024 оны жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ны хуралдаанаар тусгай зөвшөөрөл болон сүлжээний тусгай дугаартай холбогдох газар, хэлтсийн үнэлгээ, дүгнэлт болон сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт, саналыг болон ЗУХАГ-ын санал дүгнэлтийг тус тус үндэслэн тусгай зөвшөөрөл, тусгай дугаарын асуудлаар хорооны нийт 215 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно. Хорооны хуралдаанаар баталсан тогтоолоор нийтдээ 117 хуулийн этгээдэд 128 тусгай зөвшөөрөл шинээр олгосон; 104 хуулийн этгээдийн 123 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан; 17 хуулийн этгээдийн 18 тусгай зөвшөөрөлд



нэмэлт, өөрчлөлт оруулсан; 42 хуулийн этгээдийн 47 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн; 19 хуулийн этгээдийн 27 тусгай зөвшөөрлийг сэргээсэн; 9 хуулийн этгээдийн 14 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн; 53 хуулийн этгээдийн 58 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон; 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан болон нийтдээ 26 хуулийн этгээдэд 28 тусгай дугаарын зөвшөөрөл шинээр олгосон; 39 хуулийн этгээдийн 39 тусгай дугаарын зөвшөөрлийн ашиглах хугацааг сунгасан; 5 хуулийн этгээдийн 5 тусгай дугаарыг бүртгэлийг тус тус хүчингүй болгон шийдвэрлэсэн болно. Тусгай зөвшөөрлийн тогтоолуудыг албажуулан холбогдох иргэн, хуулийн этгээд нарт мэдэгдэж, ЗУХАГ-тай зөвшөөрлийн гэрээг шинээр байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон, сонгон шалгаруулалт мэдэгдэл, сунгахаас татгалзсан болгосон талаар тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд өөрчлөлт оруулан ажилласан (Хавсралт-2: ХХЗХ-ны 2024 оны хуралдаанаар шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн судалгаа).

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийн тухайд 2022 онд нийт 130 хүсэлтээс 13 (10%) нь цахимаар, 2023 онд нийт 134 хүсэлтээс 7 (5.2%) нь цахимаар ирүүлж байсан бол 2024 онд сургалт, мэдээлэл болон мэргэжил арга зүйн зөвлөмжийг иргэн, хэрэглэгч, ААН-д тогтмол өгч ажилласны үр дүнд нийт хүсэлтийн 36% нь цахимаар хүсэлт, материалаа бүрдүүлэн ирүүлсэн үзүүлэлттэй байна.

Тусгай зөвшөөрөл олгосноос хойш нэг болон хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, үйл ажиллагаагаа зогсоосон үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг гаргаж, ДЗ-ийн 2024 оны ээлжит 04 дүгээр болон 2024 оны 10 дугаар сарын 20 дугаар хуралдаанд тус тус танилцуулж, удирдамж чиглэл авч ажилласан болно. Хууль тогтоомжид нийцүүлэн сонсох ажиллагааг зохион байгуулах мэдэгдэл хүргүүлж, холбогдох санал дүгнэлт гаргаж, шийдвэрийн төслийг 2024 оны эхний 10 сарын байдлаар гаргав. Энэ асуудлыг хорооны 2024 оны 26 дугаар 2024-10-30 өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, "Тогтоолын хавсралтын холбогдох хэсгийг цуцлах тухай (ТЗ олгосон: 2023-2024 он)" Хорооны 212, 213 тоот тогтоолыг батлан тусгай зөвшөөрлүүдийг цуцлан шийдвэрлэсэн.

Тусгай зөвшөөрөл, тусгай дугаар, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хүрээнд харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчид, аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм, журам, нөхцөл, шаардлагын талаар утсаар, уулзалтаар, цахим шуудангаар 180 гаруй аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ГУРАВ.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ

ХХЗХ-ны 2024 оны гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсвийн хүрээнд Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU-International Telecommunications Union) -ын Хөгжлийн товчоо (ITU-D), Стандартчиллын товчоо (ITU-TSB)-ны хамтарсан Зөвлөх хорооны 3 дугаар хурал (ITU Advisory Committee); Азийн өргөн нэвтрүүлэг, контентын салбарын судалгаа шинжилгээний нийгэмлэгийн



Regulatory Policy Roundtable-2024, Privacy Over the Top, OTT Summit арга хэмжээ; Ази, номхон далайн шуудангийн холбооны гүйцэтгэх зөвлөлийн хурал-APPU; Ази, номхон далайн цахилгаан холбооны байгууллага-АНДЦХБ (Asia-Pacific Telecommunity, APT)-ын 2024 оны хөгжил дэвшлийн бэлтгэл уулзалт (Seminar on Progress in APT for the year 2024), Удирдлагын хорооны ээлжит жил тутмын 48 дугаар хуралдаан (48-th Session of the APT Management Committee) зэрэг олон улсын ба бүс нутгийн уулзалт, хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд 32 арга хэмжээнд давхардсан тоогоор 46 удирдлага, албан хаагч, олон улсын сургалтад 3 албан хаагчид тус тус хамрагдсан болно.

ХХЗХ-ны урилгаар МЕТА компанийн Ази, Номхон далайн бүс, төв Ази хариуцсан Олон нийтийн бодлогын хэлтсийн дарга Сенүра Абейвардена тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ХХЗХ-ны дарга Г.Чинзориг болон бусад холбогдох албан хаагчид МЕТА компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж ногоон сувгийн үр ашгийг дээшлүүлэх, Фэйсбүүк орчинд Монгол Улсын Их хурлын сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад хамтран ажиллах, сонгуулийн сурталчилгааны ил тод, нээлттэй, шударга байдлыг бүрдүүлэх, хуурамч мэдээ, мэдээлэл, хуурамч хаягийг бууруулах технологийн боломж, олон улсын чиг хандлага болон МЕТА компанийн бодлого зохицуулалт, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний талаар санал солилцов. МЕТА компанийн төлөөлөгчид нь Сонгуулийн ерөнхий хороотой хамтран цахим орчинд хүний эрхийг хамгаалах, ил тод, хариуцлагатай, сонгуулийн шударга тогтолцоог дэмжихэд улс төрийн нам, эвсэл болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд зориулсан сургалтыг 2024 оны 4 дүгээр сард зохион байгуулсан.

Зохицуулах байгууллагын хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 2024 онд БНСУ, Тайландын вант улс, Малайз, Сингапур гэсэн 4 улсын зохицуулах байгууллага /КСС, NBTC, МСМС, IMDA/-тай харилцаа тогтоож, Малайзын зохицуулах байгууллага (2024 оны 5 дугаар сар) болон Тайландын вант улсын зохицуулах (2024 оны 7 дугаар сар) байгууллагатай хоёр талын Хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулан хамтын ажиллагааг албажуулан шинэ шатанд гарган ажиллаж эхэлсэн болно.

ХХЗХ-ны төлөөлөгчид 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Сингапур улсын Мэдээлэл харилцаа холбоо, медиаг зохицуулах байгууллага (IMDA)-ын Холболт Хөгжүүлэлт, Зохицуулалтын Гүйцэтгэх Захирлын Орлогч, Харилцаа холбоо, шуудангийн Ерөнхий Захирал Хатагтай Айлин Чиа (Aileen Chia, Deputy Chief Executive of Connectivity Development and Regulation, Director-General, Telecoms and Post) болон Гадаад харилцаа хариуцсан захирал Эвелин Го (Evelin Goh, Director of International Relations, Policy and Strategy) тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж зохицуулалтын үйл ажиллагааны талаар санал солилцов.

Хөрш орнуудын харилцаа холбооны удирдах байгууллагуудад тулгардаг нэг асуудал нь хил орчмын бүс нутагт радио давтамжийг харилцан нөлөөлөлгүй ашиглах шаардлага юм. Дэлхийн радио холбооны дүрмийн 6 дугаар бүлэгт хөрш улс орнуудын харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв



байгууллагууд хооронд хил орчим ашиглах радио давтамжийн зохицуулалтын уулзалт хийх шаардлагын талаар заасан байдаг.

БНМАУ-ын Холбооны Яам, ЗСБНХУ-ын Холбооны Яамны хооронд “Хил хязгаар нутгийн хуурай замын хөдөлгөөнт албаны радио станцад метрийн ба дициметрийн цараа дахь үелзийн хэрэглээг зохицуулах тухай” хэлэлцээрийг 1983 онд Москва хотод, 2013 онд Москва хотод орчин үеийн тоон технологийн хөгжлийн зохицуулалтын эхний хэлэлцээрийг зохион байгуулж, хил орчмын бүс нутагт радио давтамжийн тодорхой зурвасуудад газрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах нийт 6 гэрээ, 2018 онд Улаанбаатар хотноо болсон 2 дах уулзалтаар радио давтамжийн зурвасуудыг хил орчим ашиглахаар өмнө байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлтүүд оруулсан ба 2500-2690 МГц, 2300-2400 МГц зурвасуудад газрын хөдөлгөөнт холбоонд ашиглах талаар 2 гэрээнд гарын үсэг зурж байсан юм. Монгол Улсын ЦХИХХЯ, ХХЗХ болон Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд 2024 оны 4 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд хооронд хил орчимд ашиглах радио давтамжийн зохицуулалтын 3 дахь удаагийн уулзалт Улаанбаатар хотод зохион байгуулагдав. Уулзалтаар радио давтамжийн 29.7-470 МГц, 450 МГц, 150 МГц, 700 МГц зурваст газрын хөдөлгөөнт болон 29.7-39.5 МГц зурваст газрын хөдөлгөөнт бус үйлчилгээний зохицуулалтын асуудлуудыг хэлэлцэн нийт 4 гэрээг шинээр байгуулахаар шийдвэрлэв.

Монгол Улсын ЦХИХХЯ, ХХЗХ болон БНХАУ-ын харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд 2024 оны 5-р сарын 21-23-ны өдрүүдэд хооронд хил орчимд ашиглах радио давтамжийн зохицуулалтын 4 дэх удаагийн уулзалт Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, радио давтамжийн 703-748/758-803 МГц, 880-915/925-960 МГц, 1710-1785/1805-1880 МГц, 2300-2400 МГц, 2500-2690 МГц, 1920-1980/2110-2170 МГц, 3300-3800 МГц зурвасуудад газрын хөдөлгөөнт, газрын хөдөлгөөнт бус үйлчилгээний зохицуулалтын асуудлуудыг хэлэлцэв. Хэлэлцүүлгийн явцад талууд хил орчмын радио давтамжийн зурвасуудын хуваарилалт, хэрэглээний талаар мэдээлэл солилцож, хил орчмын бүс нутагт хоёр улсын радио давтамжийн хяналтын үйл ажиллагаа, хийсэн хэмжилт шалгалтын үр дүнд илэрсэн радио давтамжийн харилцан нөлөөллийн талаар танилцуулсан.

Радио давтамжийн тодорхой зурвасуудын зохицуулалтын арга механизмыг дахин судлах, тухайлбал нэвтрүүлэгчийн цацаргаж байгаа цахилгаан соронзон орны хүчилгийн (E) хилийн зурвас дахь босго утгыг тохиролцох ба энэ удаагийн уулзалтаас хойш 6 сарын хугацаанд хоёр тал хилийн зурваст туршилтын хэмжилт хийж, мэдээлэл солилцон санал нийлсэн тохиолдолд гэрээ байгуулах боломжтой гэж тохирлоо. Энэ удаагийн хэлэлцээрийн үр дүнд Монгол Улс болон БНХАУ-ын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагууд хооронд радио давтамжийн 1920-1965/2110-2155 МГц зурвасыг хил орчмын бүс нутагт газрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах тухай гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан нь хоёр улсын гадаад харилцааг хөгжүүлэхэд чухал алхам болсон.



Олон Улсын Цахилгаан холбооны байгууллага болон Далайд гарцгүй орнуудын олон улсын судалгааны төв, ЦХИХХЯ, ХХЗХ хамтран “Ази-Номхон далайн Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын харилцаа холбооны салбарын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг шийдвэрлэх нь” сэдэвт семинарыг 2024 оны 10 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Семинарт 14 орны зочид төлөөлөгчид оролцож, өөрсдийн орны харилцаа холбооны дэд бүтэц, үндэсний хиймэл дагуулын хөтөлбөр, түүний зохицуулалтын механизмын талаар туршлагаа хуваалцлаа. Мөн Олон улсын цахилгаан холбооны байгууллага, хиймэл дагуулын Амазон, Софтбанк, Интелсат зэрэг компаниуд Хиймэл дагуулын хөгжлийн цаашдын хандлага, түүний зохицуулалт ба ирээдүй, хиймэл дагуултай холбоотой P2C түншлэлийн тодорхой боломжуудын талаар танилцуулав.

Дэлхийн Шуудангийн холбооны (ДШХ) Ази-Номхон Далайн бүсийн орнуудын Стратегийн форум 2024 оны 9 сард Монгол Улсад анх удаа зохион байгуулсан. Ази-Номхон далайн бүс нутгийн 32 орны 100 орчим төлөөлөгчид, улс орнуудын үндэсний шуудангийн үйлчилгээ үзүүлэгчид, зохицуулагчид, бодлого боловсруулагчид, ХХЗХ-ны дарга Г.Чинзориг, албаны төлөөлөгчид оролцов.

Хорооны гишүүн, ажлын албаны дарга А.Лувсан-Очир тэргүүтэй ХХЗХ-ны баг 2024 оны 11 сард зохицуулах байгууллагын хуулийн этгээдийн статусыг тодорхойлох талаар ОУЦХБ (ITU), Дэлхийн худалдааны байгууллага (WTO) зэрэг олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, бодлогын зөвлөлдөх албан уулзалтыг Монгол Улсын ЭСЯ, ОУЦХБ-ын удирдлагын төлөөлөл, ДХБ-ын Эрх зүйн асуудлаарх зөвлөх төв-ACWL байгууллагын захирал нартай уулзан мэдээлэл солилцож, холбогдох дүгнэлтийг гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж эхэлсэн болно.

Монгол Улс, БНСУ-ын хоорондын Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийн гурав дахь шатны хэлэлцээр 2024 оны 09 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Хэлэлцээрийн зорилго нь худалдааны урсгалыг жигд, үр ашигтай явуулахын тулд тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг бууруулах, худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хоёр талын хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан ашигтай эдийн засгийн түншлэлээ өргөжүүлэн хөгжүүлэх, хоёр орны бизнес эрхлэгчид, иргэдэд шинэ боломжуудыг бий болгоход чиглэгдсэн юм. ХХЗХ-ноос ЗБТХ-ээс Худалдаа үйлчилгээний бүлгийн Цахилгаан холбооны дэд бүлгийг ахалж ЭЗХЯ-аас баталсан хэлэлцээрт баримтлах чиглэлийг баримтлан хэлэлцээрт оролцож, тус Хорооноос дээрх хэлэлцээрийн цахим худалдааны ажлын хэсгийн хэлэлцээрт оролцсон. Хэлэлцээрээс хэлэлцсэн асуудлын товч дүгнэлтийг гаргаж, хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү хэлэлцээрийн 4 дэх шатны хэлэлцээр БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 11 дүгээр сарын 24-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, уг хэлэлцээрт Худалдаа үйлчилгээний бүлгийн Цахилгаан холбооны дэд бүлгийг ахалж, ЭЗХЯ-наас баталсан хэлэлцээрт баримтлах чиглэлийн дагуу цахилгаан холбооны дэд бүлгийн текстийг эцэслэж хаалтын үйл ажиллагаанд хэлэлцээрийн явцын талаар мэдэгдэл хийж оролцсон. Хэлэлцсэн асуудлын товч дүгнэлтийг тохиролцож баталгаажуулан 2 тал гарын үсэг зурж, ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн болно.



Гадаад хамтын ажиллагаатай болон бусад байгууллагуудын төлөөлөгч нартай 2024 онд хоёр талын уулзалт, хамтын ажиллагааны хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тухайлбал, Гадаад хамтын ажиллагаатай байгууллагууд болох Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, Хүний эрхийн алба (АИХЭА), APNIC, Meta , AP IntelSat, Fonet, Хил хязгааргүй сэтгүүлчид ТББ, Японы JICA, KDDI foundation, Тайпэйн худалдаа, Эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газар, БНСУ-ын KAIST, ОУЦХБ-ITU, Малайз улсын зохицуулах байгууллага-MCMC, RRA,RAPA, бусад Олон улсын зохицуулах хороо, Тайландын вант улсын зохицуулах байгууллага-NBTC зэрэг байгууллагуудын төлөөлөгч нарыг хүлээн авч, уулзалт зохион байгуулсан.

ДӨРӨВ.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ӨР АВЛАГЫН БАРАГДУУЛАЛТ

ХХЗХ-ны хуралдаанаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 3 бүлэгт стратегийн зорилтын хүрээнд 308 (үүнээс, 208 хугацаатай, 103 байнга хэрэгжүүлэх) бүтээгдэхүүн, зорилт заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж, хорооны ажлын алба, бүтцийн нэгж 11 субъектээс 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан бүтээгдэхүүн, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж, улирал бүр тайлагнан ажиллав.

Хорооны 2024 оны ээлжит, ээлжит бус 30 удаагийн хуралдааны мэдээний төслийг боловсруулж, баталсан тогтоол шийдвэр, тэмдэглэлийг албажуулах, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлсэн 2024 оны 6 тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулан олон нийт, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт ил тод, нээлттэй, цахимаар авах боломжийг бүрдүүлэв.

ХХЗХ-ны Даргын зөвлөлийн хурлыг 2024 онд нийтдээ 29 удаа зохион байгуулан 142 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдамж чиглэл гарган ажиллав.

ХХЗХ-ны даргын бүрэн эрхийн хүрээнд 2024 онд нийтдээ удирдлага, зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 340, хөдөлмөрийн харилцаатай холбоотой Б тушаал 84 тус тус баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав.

Төрийн мэдээллийн үндсэн сүлжээний тусгай хэрэгцээний сүлжээнд холбогдоход шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, ҮАБЗ-ийг мэдээллээр хангах үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд "Баримт бичгийн удирдлагын систем"-ийг (DMS)-тэй холболт хийж, тайланг цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн.

Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем (customer.crc.gov.mn)- д нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд Төрийн мэдээллийн үндсэн болон дэмжих системүүдтэй холболт хийж ХҮР системээс байгууллага, иргэний мэдээлэл авдаг болсон. Тусгай



зөвшөөрлийн төлбөр тооцооны программ болон шинээр хийгдэж буй статистикийн системтэй интеграц хийх, ажилтнуудын нэвтрэлтийг нэг болгох (SSO) сервисүүдийг хөгжүүлж боломжийг бий болгосон. Цаасаар ирсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хэрэглэгчийн системд үүсгэж, хэрэглэгч явцыг хянах боломжийг бүрдүүлэв.

